

## ДААТГАГЧИЙН ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэ журмын зорилго нь даатгагч даатгуулагчийн өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлэхэд хүрэлцэхүйц хэмжээний хөрөнгөтэй эсэхийг тодорхойлох, төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцоолох, даатгагчийн эрсдэлийн түвшинг үнэлэх, түүнд Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ноос хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2 Даатгагч хөрөнгийн эрсдэлийг тооцоолоход нөлөөлөх дараах үзүүлэлтүүдийг авч үзнэ. Үүнд:

- 1.2.1 Зах зээлийн эрсдэл;
  - 1.2.1.1.Хүүгийн эрсдэл;
  - 1.2.1.2.Валютын ханшийн эрсдэл;
  - 1.2.1.3.Хувьцааны эрсдэл;
  - 1.2.1.4.Инфляцийн эрсдэл;
  - 1.2.1.5.Хөрөнгийн эрсдэл;

- 1.2.2 Зээлийн эрсдэл;
- 1.2.3 Андеррайтингийн эрсдэл;
- 1.2.4 Үйл ажиллагааны эрсдэл;
- 1.2.5 Бусад шаардлагатай үзүүлэлтүүд.

1.3 Даатгагч төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцоолохдоо холбогдох эрх бүхий ажилтнаар баталгаажсан санхүүгийн тайлан, тэнцлийн үзүүлэлтүүдийг ашиглана.

1.4 Даатгагч энэ журмын 1, 3, 4 дүгээр хавсралтын дагуу хөрөнгөө байршуулахад Даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан хязгаарлалтыг харгалзахаас гадна дараах этгээдээс бусад этгээдэд хөрөнгө оруулалт байршуулж болно.

- 1.4.1 даатгалын тухай хуулийн 4.1.12-т заасан холбогдох этгээд;
- 1.4.2 барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэлгээ нь зээлийн үндсэн өр болон хүүгийн төлбөрийг барагдуулахад хүрэлцэхгүй байгаа иргэн, хуулийн этгээд;
- 1.4.3 холбогдох этгээдтэй хэрэг, маргаан үүссэний улмаас эрх бүхий байгууллагаар хянагдаж, шалгагдаж байгаа этгээд;
- 1.4.4 даатгалын компани өөрөө холбогдох этгээд гэж үзсэн бусад этгээд.

### Хоёр. Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

2.1 Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг энэ журмын арав нэгдүгээр хавсралтын дагуу хөрөнгийн хүрэлцээний харьцаа болон муу хөрөнгийн харьцаа үзүүлэлтээр тооцоолж, даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцааг тодорхойлно.

2.2 Хөрөнгийн хүрэлцээний харьцааг даатгагчийн өөрийн хөрөнгийн дүнг зайлшгүй байх хөрөнгийн дүнд хуваах замаар буюу дараах томъёогоор тооцно.

$$\boxed{XXX = ДӨХ / ЗБХ * 100\%}, \text{ Үүнд:}$$

XXX – хөрөнгийн хүрэлцээний харьцаа  
ЗБХ – зайлшгүй байх хөрөнгийн дүн

ДӨХ – даатгагчийн өөрийн хөрөнгийн дүн

2.3 Ердийн даатгагчийн өөрийн хөрөнгийн дүнг даатгагчийн нийт хөрөнгөөс нийт өр төлбөрийн дүн болон даатгалын хөрөнгийн дүнг хасч, тусгай нөөц сангийн дүнг нэмэх замаар буюу дараах томъёогоор тооцно.

$$\boxed{\text{ДӨХ} = \text{ДНХ} - \text{ДХД} - \text{НӨТ} + \text{ТНС}}, \text{ Үүнд:}$$

ДНХ – даатгагчийн нийт хөрөнгийн дүн /Даатгагчийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүн/

НӨТ – нийт өр төлбөрийн дүн /санхүүгийн тайлангийн нийт өр төлбөрийн дүн/

ТНС – тусгай нөөц сангийн дүн /санхүүгийн тайлангийн тусгай нөөц сангийн дүн/

ДХД- даатгалын хөрөнгийн дүн /санхүүгийн тайлангийн нийт даатгалын хөрөнгийн дүн/

2.4 Урт хугацааны даатгагч болон давхар даатгагчийн өөрийн хөрөнгийн дүнг даатгагчийн нийт хөрөнгөөс нийт өр төлбөрийн дүн болон даатгалын хөрөнгийн дүнг хасах замаар буюу дараах томъёогоор тооцно.

$$\boxed{\text{ДӨХ} = \text{ДНХ} - \text{ДХД} - \text{НӨТ}}, \text{ Үүнд:}$$

ДНХ – даатгагчийн нийт хөрөнгийн дүн /Даатгагчийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүн/

НӨТ – нийт өр төлбөрийн дүн /санхүүгийн тайлангийн нийт өр төлбөрийн дүн/

ДХД- даатгалын хөрөнгийн дүн /санхүүгийн тайлангийн нийт даатгалын хөрөнгийн дүн/

2.5 Энэ журмын 2.2-д заасан зайлшгүй байх хөрөнгийг даатгагчийн эрсдэлд суурилсан хөрөнгийн дүн болон Хорооноос тогтоосон дүрмийн сангийн доод хэмжээний аль ихээр буюу дараах томъёогоор тооцно.

$$\boxed{\text{ЗБХ} = \max(\text{ЭСХ}; \text{ДСДХ})}, \text{ Үүнд:}$$

ДСДХ – Хорооноос тогтоосон дүрмийн сангийн доод хэмжээ

ЭСХ – эрсдэлд суурилсан хөрөнгийн дүн

2.6 Даатгагчийн эрсдэлд суурилсан хөрөнгийн дүн гэдэг нь тухайн даатгагчийн үйл ажиллагаа явуулахад гарч буй эрсдэл тус бүрээр тооцсон хөрөнгийн нийлбэрээс төрөлжүүлэлтийн бууралт болон хойшлогдсон татварын өр төлбөрийг хасч тодорхойлно.

$$\text{ЭСХ} = (\text{ЗЗЭ} + \text{ЗЭ} + \text{АЭ} + \text{ҮАЭ}) - \text{ТБ} - \text{ХТ}, \text{ Үүнд:}$$

ЗЗЭ – зах зээлийн эрсдэлд суурилсан хөрөнгө

ЗЭ – зээлийн эрсдэлд суурилсан хөрөнгө

АЭ - андеррайтингийн эрсдэлд суурилсан хөрөнгө

ҮАЭ – үйл ажиллагааны эрсдэлд суурилсан хөрөнгө

ТБ – төрөлжүүлэлтийн бууралт

ХТ – хойшлогдсон татварын өр төлбөр

2.7 Даатгагч нь эрсдэлд суурилсан хөрөнгийн дүнг тооцохдоо даатгагчийн эрсдэл тус бүрийн хувьд дараах үзүүлэлтийг харгалзах эрсдлийн коэффициентээр үржүүлж тооцно:

2.7.1 зах зээлийн эрсдэлд суурилсан хөрөнгийн дүнг тооцохдоо энэ журмын 1 дүгээр хавсралтад заасны дагуу тухайн хөрөнгийн ангилал дахь дүнг;

2.7.2 зээлийн эрсдэлд суурилсан хөрөнгийн дүнг тооцохдоо энэ журмын 3 дугаар хавсралтад заасны дагуу тухайн хөрөнгийн ангилал дахь дүнг;

2.7.3 андеррайтингийн эрсдэлд суурилсан хөрөнгийн дүнг тооцохдоо ердийн болон давхар даатгагчид энэ журмын 5 дугаар хавсралтад заасны дагуу, урт

хугацааны даатгагчид энэ журмын 7 дугаар хавсралтын дагуу даатгалын хэлбэр тус бүрийн хувьд даатгалын хураамжийн болон даатгалын нөхөн төлбөрийн нөөц сангийн дүнг (давхар даатгагчид ноогдох хэсгийг хассан дүн);

2.7.4 үйл ажиллагааны эрсдэлд суурилсан хөрөнгийн дүнг тооцохдоо энэ журмын 2.3 болон 2.4-т заасан нийт өөрийн хөрөнгийн дүнг үйл ажиллагааны эрсдэлийн коэффициент буюу 3 хувиар;

2.8 Ердийн болон давхар даатгагчийн андеррайтингийн эрсдэлийн коэффициентийг тооцохдоо хураамжийн эрсдэл болон нөхөн төлбөрийн эрсдэл гэж 2 ангилна.

2.8.1 Хураамжийн эрсдэлийн коэффициентийн тооцоололд beta тархалтын муруйг ашиглан тухайн даатгалын хэлбэрт тохирсон alpha, beta-д үндэслэн арван хоёрдугаар хавсралтын дагуу тооцсон.

2.8.2 Нөхөн төлбөрийн эрсдэлийн коэффициентийн тооцоололд normal тархалтын муруйг тухайн даатгалын хэлбэрт тохирсон mu, sigma-д үндэслэн арван гуравдугаар хавсралтын дагуу тооцсон.

2.9 Эрсдэлд суурилсан хөрөнгийн дүнг тодорхойлохдоо эрсдэлийн хамаарлыг харгалзах бөгөөд энэ журмын 2.6-д заасан эрсдэлд суурилсан хөрөнгийн дүнг, эрсдэл тус бүрийн хамаарлын коэффициентээр үржүүлж буюу дараах томъёогоор тооцох бөгөөд зах зээлийн эрсдэлийн хувьд энэ журмын 2 дугаар, зээлийн эрсдэлийн хувьд энэ журмын 4 дүгээр, андеррайтингийн эрсдэлийн хувьд энэ журмын 6 дугаар болон 7 дугаар хавсралтад заасан хамаарлын коэффициентийг ашиглана.

$$HЭ = \sum_{i=1}^n YY, \text{ Үүнд:}$$

HЭ – нийт эрсдэл

YY – эрсдэлийн нийлбэр дүнг хамаарлын коэффициентээр үржүүлсэн дүн

n – энэ журмын 1, 3 болон 5 дугаар хавсралтад заасан хөрөнгийн ангилал эсвэл даатгалын хэлбэрийн тоо

i – энэ журмын 1, 3 болон 5 дугаар хавсралтад заасан хөрөнгийн ангилал эсвэл даатгалын хэлбэрийн дугаар

2.10 Төрөлжүүлэлтийн бууруулалтыг тооцохдоо энэ журмын 2.6-д заасны дагуу тооцсон зах зээлийн эрсдэл, зээлийн эрсдэл, андеррайтингийн эрсдэлүүдийн хамаарлаар бууруулах буюу дараах томъёогоор тооцно:

$$TB = \sqrt{33Э^2 + 3Э^2 + АЭ^2}, \text{ Үүнд:}$$

2.11 Муу хөрөнгийн харьцааг нийт өөрийн хөрөнгийн дүнг муу хөрөнгийн дүнд хуваах замаар буюу дараах томъёогоор тооцно.

$$MXX = MX / ДНХ * 100, \text{ Үүнд:}$$

MXX - муу хөрөнгийн харьцаа

MX - муу хөрөнгө /Даатгагчийн санхүүгийн байдлын тайлангийн даатгалын авлага, бусад авлага болон хэвийн авлагын 50 хувьтай тэнцэх дүн болон биет бус хөрөнгийн нийлбэр дүн /

ДНХ – даатгагчийн нийт хөрөнгө /Даатгагчийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүнгээс даатгалын хөрөнгийн дүнг хассан дүн/

2.12 Дараах хүснэгтийн дагуу авлагыг төлөхөөр тохиролцсон огноо буюу бичгээр хийсэн хэлцэлд тусгагдсан төлөгдөх хугацаа дууссанаас хойших хугацаанаас эхлэн хугацааг тооцож дүгнэн, авлагыг ангилна: (авлагын төлөгдөх хугацааг 1 удаа 120 хүртэлх хоногоор сунгасан тохиолдолд тухайн авлагыг хэвийн авлагаар, 1 удаа 121-ээс дээш хоногоор сунгасан тохиолдолд эргэлзээтэй авлагаар, 2 ба түүнээс дээш удаа авлагын төлөгдөх хугацааг сунгасан тохиолдолд тухайн авлагыг эргэлзээтэй авлагаар тооцно. Эргэлзээтэй авлагаар тооцож эхэлснээс хойш 30 хоногийн дотор төлөгдөөгүй бол тухайн авлагыг муу авлагаар тооцно):

Ангилал	Хэвийн	Хугацаа хэтэрсэн	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу
Хугацааны үзүүлэлт	30 хүртэл хоногийн дотор байгаа	31-60 хоногийн дотор төлөгдөөгүй	61-90 хоногийн дотор төлөгдөөгүй	91-120 хоногийн дотор төлөгдөөгүй	121-ээс дээш хоногоор төлөгдөөгүй буюу гэмт хэргийн улмаас бий болсон авлага

2.13 Энэ журмын 2.2-т заасан хөрөнгийн хүрэлцээний байвал зохих харьцааг дараах 2 түвшинд тогтооно:

2.13.1 Даатгагчийн эрсдэлд суурилсан хөрөнгийн дүн Хорооноос тогтоосон дүрмийн сангийн доод хэмжээнээс их байх тохиолдолд хөрөнгийн хүрэлцээний байвал зохих харьцаа 200 хувь ба түүнээс дээш байна.

2.13.2 Даатгагчийн эрсдэлд суурилсан хөрөнгийн дүн Хорооноос тогтоосон дүрмийн сангийн доод хэмжээнээс бага байх тохиолдолд байвал зохих харьцаа 150 хувь ба түүнээс дээш байна.

2.14 Даатгагчийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа байвал зохих харьцаанаас 10 хүртэл хувиар бага буюу 140-149, 190-199 хувийн хооронд байвал тухайн даатгагчийг эрсдэлд орж болзошгүй гэж үзнэ.

2.15 Хэрэв даатгагчийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа байвал зохих харьцаанаас 10-аас их хувиар бага буюу 139, 189 хувиас бага байвал тухайн даатгагчийг эрсдэл даах чадваргүй болсонд тооцно.

2.16 Энэ журмын арван нэгдүгээр хавсралтын дагуу Хороо даатгагчийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа болон муу хөрөнгийн харьцааны уялдаагаар даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцоолж, даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцааг дараах байдлаар тодорхойлж, зохицуулагчийн зүгээс дараах шаардлагыг өгч болно.

2.16.1 1 дүгээр түвшин буюу даатгагчийн эрсдэл үнэмлэхүй өндөр хэмжээнд хүрсэн тохиолдолд даатгагч эрсдэлийг бууруулах чиглэлээр нэн даруй арга хэмжээ авах шаардлагатай буюу зайны болон газар дээрх хяналт шалгалтыг явуулах, шаардлагатай гэж үзвэл Даатгалын тухай хуулийн 68 дугаар зүйлд заасан албадлагын арга хэмжээ авах;

2.16.2 2 дугаар болон 3 дугаар түвшин буюу даатгагчийн эрсдэл харьцангуй өндөр байгаа тохиолдолд даатгагч эрсдэлийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээ авах буюу зайны болон газар дээрх хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх;

2.16.3 4 дүгээр болон 5 дугаар түвшин буюу даатгагчийн эрсдэл дундаж байгаа тохиолдолд даатгагчийг төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг сайжруулахыг шаардаж, шаардлагатай тохиолдолд зайны болон газар дээрх хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх;

2.16.4 6 дугаар түвшинд эрсдэлийн түвшин харьцангуй бага байгаа тохиолдолд даатгалын компани сайжруулах шаардлагатай зүйлсийг тодорхойлж, Хороонд төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн төлөвлөгөөг ирүүлэх;

2.16.5 7 дугаар болон 8 дугаар түвшин буюу эрсдэлийн түвшин сайн тул хяналт шалгалтын үйл ажиллагааг хэвийн хэрэгжүүлнэ.

#### Гурав. Хяналт, хариуцлага

3.1 Даатгагч нь хөрөнгийг гадаад улсад байршуулахаар бол Хороонд хүсэлтээ бичгээр тавих ба Хорооны хяналт шалгалтын асуудал эрхэлсэн газар зөвшөөрөл олгох эсэхийг даатгагч албан бичиг ирүүлсэн өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор шийдвэрлэж, хариуг даатгагчид албан бичгээр хүргүүлнэ.

3.2 Даатгагч нь энэ журмын хавсралт маягтуудын дагуу төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцоолон гаргаж, улирал бүр санхүүгийн тайлангийн хамт цаасаар болон цахимаар Хороонд хүргүүлнэ.

3.3 Энэ журмын арван хоёрдугаар болон арван гуравдугаар хавсралтад заасан андеррайтингийн эрсдэлийн коэффициентийг илүү боловсронгуй, тухайн даатгагчид тохирсон тархалтын болон  $\alpha$ ,  $\beta$ -гийн дагуу тооцоолж болох бөгөөд уг тооцооллыг Хороонд ирүүлж хянуулсны дагуу эрсдэлийн коэффициентуудыг өөрчлөн төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцоолж болно.

3.4 Энэ журмын 3.2-т заасан даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлан нь даатгагчийн өөрийн эрсдэл болон төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн үнэлгээний тайлангийн нэг хэсэг бөгөөд даатгагч уг тайланг энэ журмын арван долоодугаар хавсралтын дагуу боловсруулсан өөрийн эрсдэлийн үнэлгээний тайлангийн хамт Хороонд хүргүүлнэ. Даатгагч нь сар бүр, шаардлагатай гэж үзвэл тухайн бүрд төлбөрийн чадварын зохистой харьцааг тооцох боломжтой байх шаардлагатай.

3.5 Хороонд хүргүүлсэн төлбөрийн чадварын зохистой харьцааны тооцоололд Хорооны хяналт шалгалтын асуудал эрхэлсэн газар хяналт тавьж, баталгаажуулах бөгөөд тайлантай холбогдуулан шаардлагатай гэж үзвэл нэмэлт мэдээлэл, материал шаардаж болно.

3.6 Энэ журмын 2.14, 2.15-т заасны дагуу даатгагч эрсдэл даах чадваргүй болж болзошгүй болон эрсдэл даах чадваргүй болсон тохиолдолд Хорооноос тогтоосон хугацаанд энэхүү нөхцөл байдалд хүргэсэн хүчин зүйлүүдийг тодорхойлж, тэдгээрийн нөлөөллийг үе шаттайгаар бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан Хороонд хүргүүлнэ.

3.7 Хороо энэ журмын 3.6-д заасан төлөвлөгөөг хянаж, шаардлагатай тохиолдолд даатгагчид зөвлөмж хүргүүлэн, тус төлөвлөгөөний дагуу ажиллаж буй эсэхэд хяналт тавина.

3.8 Хороо энэ журмын хэрэгжилтэд байнга хяналт тавих бөгөөд зөрчсөн этгээдэд Даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны ... дугаар  
сарын ....-ны өдрийн .... дүгээр тогтоолоор баталсан  
“Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур  
үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ын нэгдүгээр хавсралт

МАЯГТСЗХ04150.“..... “ ХХК-ийн 20.... оны ..... дүгээр улирлын  
Зах зээлийн эрсдэлийн тооцоолол

№	Зах зээлийн эрсдэлийн ангилал	Коэффициент (%)*	Дүн	Эрсдэл
1	Хүүгийн эрсдэл			
1.1	<u>Хугацаагүй</u>			
1.1.1	Харилцах, хугацаагүй хадгаламж	7.00%		
1.1.2	Банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулсан хөрөнгө	7.00%		
1.2	<u>Хугацаатай</u>			
1.2.1	0-1 жил	1.00%		
1.2.2	1-5 жил	11.00%		
1.2.3	5 ба түүнээс дээш жил	10.00%		
	Нийт хүүгийн эрсдэл			
2	Валютын ханшийн эрсдэл			
2.1	АНУ доллар			
2.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө (валют)	8.83%		
2.1.2	Давхар даатгалаас авах авлага	8.83%		
2.1.3	ДД-ын хойшлогдсон хураамж	8.83%		
2.1.4	Нөхөн төлбөрийн нөөцийн ДД-д ногдох хэсэг	8.83%		
2.1.5	Нийт			
2.2	Евро			
2.2.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө (валют)	3.00%		
2.2.2	Давхар даатгалаас авах авлага	3.00%		
2.2.3	ДД-ын хойшлогдсон хураамж	3.00%		
2.2.4	Нөхөн төлбөрийн нөөцийн ДД-д ногдох хэсэг	3.00%		
2.2.5	Нийт			
2.3	Японы иен			
2.3.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө (валют)	8.50%		
2.3.2	Давхар даатгалаас авах авлага	8.50%		
2.3.3	ДД-ын хойшлогдсон хураамж	8.50%		

2.3.4	Нөхөн төлбөрийн нөөцийн ДД-д ногдох хэсэг		8.50%		
2.3.5	Нийт				
2.4	Английн фунт				
2.4.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө (валют)		1.50%		
2.4.2	Давхар даатгалаас авах авлага		1.50%		
2.4.3	ДД-ын хойшлогдсон хураамж		1.50%		
2.4.4	Нөхөн төлбөрийн нөөцийн ДД-д ногдох хэсэг		1.50%		
2.4.5	Нийт				
2.5	ОХУ-ын рубль				
2.5.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө (валют)		6.00%		
2.5.2	Давхар даатгалаас авах авлага		6.00%		
2.5.3	ДД-ын хойшлогдсон хураамж		6.00%		
2.5.4	Нөхөн төлбөрийн нөөцийн ДД-д ногдох хэсэг		6.00%		
2.5.5	Нийт				
2.6	БНХАУ-ын юань				
2.6.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө (валют)		2.00%		
2.6.2	Давхар даатгалаас авах авлага		2.00%		
2.6.3	ДД-ын хойшлогдсон хураамж		2.00%		
2.6.4	Нөхөн төлбөрийн нөөцийн ДД-д ногдох хэсэг		2.00%		
2.6.5	Нийт				
2.7	БНСУ-ын вон				
2.7.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө (валют)		2.50%		
2.7.2	Давхар даатгалаас авах авлага		2.50%		
2.7.3	ДД-ын хойшлогдсон хураамж		2.50%		
2.7.4	Нөхөн төлбөрийн нөөцийн ДД-д ногдох хэсэг		2.50%		
2.7.5	Нийт				
2.8	ДД өгөх өглөг	АНУ доллар	8.83%		
		Евро	3.00%		
		Японы иен	8.50%		
		Английн фунт	1.50%		
		ОХУ-ын рубль	6.00%		
		БНХАУ-ын юань	2.00%		
		БНСУ-ын вон	2.50%		
Нийт валютын ханшийн эрсдэл					
3	Хувьцааны эрсдэл				
3.1	Үнэт цаас (цэвэр)				

3.1.1	ХХК	20.00%		
3.1.2	ХК - Борлуулахад бэлэн үнэт цаас	10.00%		
3.1.3	ХК - Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас	20.00%		
3.1.4	Хараат ба хамтын хяналттай, охин компаниудад оруулсан хөрөнгө оруулалт	30.00%		
3.1.5	Үнэт металл, Дериватив	30.00%		
Нийт хувьцааны эрсдэл				
4	Хөрөнгийн эрсдэл			
4.1	<u>Үндсэн хөрөнгө (цэвэр)</u>			
4.1.1	Газрын сайжруулалт	5.00%		
4.1.2	Барилга байгууламж	15.00%		
4.1.3	Машин тоног төхөөрөмж	20.00%		
4.1.4	Тээврийн хэрэгсэл	35.00%		
4.1.5	Тавилга эд хогшил	40.00%		
4.1.6	Компьютер дагалдах хэрэгсэл	45.00%		
4.1.7	Санхүүгийн түрээсийн хөрөнгө	15.00%		
4.1.8	Мал сүрэг	15.00%		
4.1.9	Барьцаалсан хөрөнгө /Холбогдох хууль тогтоомжийн дагуу барьцаалсан эд хөрөнгө/	65.00%		
4.2	Виртуал хөрөнгө / “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай” хуулийн 4.1.1-т заасан хөрөнгө/	90.00%		
Нийт хөрөнгийн эрсдэл				

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны ... дугаар  
сарын ....-ны өдрийн .... дүгээр тогтоолоор баталсан  
“Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур  
үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ын хоёрдугаар хавсралт

МАЯГТСЗХ04151. “..... “ ХХК-ийн 20... оны ..... дүгээр  
улирлын зах зээлийн эрсдэлийн хамаарлын тооцоолол

Эрсдэлийн ангилал	Хүүгийн эрсдэл	Валютын ханшийн эрсдэл	Хувьцааны эрсдэл	Хөрөнгийн эрсдэл
Эрсдэл				
Эрсдэлийн хамаарал				
Хүүгийн эрсдэл	1.00			
Валютын ханшийн эрсдэл		1.00		
Хувьцааны эрсдэл			1.00	
Хөрөнгийн эрсдэл				1.00
Нийт эрсдэл				

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны ... дугаар  
сарын ....-ны өдрийн .... дүгээр тогтоолоор баталсан  
“Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур  
үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ын гуравдугаар хавсралт

МАЯГТСЗХ04152. “.....” “ХХК-ийн 20... оны ..... дүгээр  
улирлын зээлийн эрсдэлийн тооцоолол

№	Зээлийн эрсдэлийн ангилал	Коэффициент (%)*	Дүн	Эрсдэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө			
1.1	Дотоодын банкин дахь харилцах, хугацаагүй хадгаламж	10.00%		
1.2	Банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулсан хөрөнгө	20.00%		
Нийт				
2	Даатгалын авлага			
2.1	Хэвийн	0.00%		
2.2	Хугацаа хэтэрсэн	25.00%		
2.3	Хэвийн бус	50.00%		
2.4	Эргэлзээтэй	100.00%		
2.5	Муу	100.00%		
Нийт				
3	Давхар даатгалаас авах авлага			
3.1	Guaranteed	0.00%		
3.2	AA or higher	1.60%		
3.3	A	4.00%		
3.4	BBB	8.00%		
3.5	BB	16.00%		
3.6	B or lower	24.00%		
3.7	Unrated, secured	30.00%		
3.8	Unrated, unsecured	100.00%		
Нийт				
4	Бусад авлага			
4.1	Хэвийн	0.00%		
4.2	Хугацаа хэтэрсэн	25.00%		
4.3	Хэвийн бус	50.00%		
4.4	Эргэлзээтэй	100.00%		
4.5	Муу	100.00%		
Нийт				
5	Хадгаламж, хадгаламжийн сертификат			
5.1	Guaranteed	0.00%		
5.2	AA or higher	1.60%		

5.3	A	4.00%		
5.4	BBB	8.00%		
5.5	BB	16.00%		
5.6	B or lower	24.00%		
5.7	Unrated, secured	30.00%		
5.8	Unrated, unsecured	100.00%		
Нийт				
6	ДД-ын хойшлогдсон хураамж			
6.1	Guaranteed	0.00%		
6.2	AA or higher	1.60%		
6.3	A	4.00%		
6.4	BBB	8.00%		
6.5	BB	16.00%		
6.6	B or lower	24.00%		
6.7	Unrated, secured	30.00%		
6.8	Unrated, unsecured	100.00%		
Нийт				
7	Нөхөн төлбөрийн нөөцийн ДД-ын ногдох хэсэг			
7.1	Guaranteed	0.00%		
7.2	AA or higher	1.60%		
7.3	A	4.00%		
7.4	BBB	8.00%		
7.5	BB	16.00%		
7.6	B or lower	24.00%		
7.7	Unrated, secured	30.00%		
7.8	Unrated, unsecured	100.00%		
Нийт				
8	Үнэт цаас (цэвэр)			
8.1	Засгийн газраас гаргасан өрийн хэрэгсэл	0.00%		
8.2	Төв банкны үнэт цаас	0.00%		
8.3	Ногоон бонд	10.00%		
8.4	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	10.00%		
8.5	Аймаг нийслэлийн гаргасан өрийн хэрэгсэл	10.00%		
8.6	Компанийн өрийн хэрэгсэл	20.00%		
8.7	Монголын хөрөнгийн биржийн хувьцаат компанийн хувьцаа – 1 ангилал	20.00%		
8.8	Монголын хөрөнгийн биржийн хувьцаат компанийн хувьцаа – 2 ангилал	30.00%		
8.9	Хөрөнгө оруулалтын нээлттэй сан	30.00%	-	-

8.10	Хөрөнгө оруулалтын хаалттай сан	30.00%		
8.11	Гадаадын Засгийн газраас гаргасан өрийн хэрэгсэл	5.00%		
8.12	Гадаадын Төв банкны үнэт цаас	5.00%		
8.13	Гадаадын компанийн өрийн хэрэгсэл	20.00%		
8.14	Гадаадын компанийн хувьцаа	20.00%		
Нийт				



Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны ... дугаар  
сарын ....-ны өдрийн .... дүгээр тогтоолоор баталсан  
“Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур  
үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ын тавдугаар хавсралт

МАЯГТСЗХ04156. “..... “ ХХК-ийн 20... оны ..... дүгээр  
улирлын андеррайтингийн эрсдэлийн тооцоолол

№	Андеррайтингийн эрсдэлийн ангилал	Коэффициент (%)*	Дүн	Эрсдэл
1	Хураамжийн эрсдэл			
1.1	Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	40%		
1.2	Хөрөнгийн даатгал	20%		
1.3	Авто тээврийн хэрэгслийн даатгал	20%		
1.4	Ачааны даатгал	34%		
1.5	Барилга угсралтын даатгал	65%		
1.6	Газар тариалангийн даатгал	80%		
1.7	Мал амьтдын даатгал	45%		
1.8	Агаарын хөлгийн даатгал	60%		
1.9	Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	30%		
1.10	Хариуцлагын даатгал	40%		
1.11	Санхүүгийн даатгал	35%		
1.12	Зээлийн даатгал	60%		
1.13	Итгэлцлийн даатгал	40%		
1.14	Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	20%		
1.15	Жолоочийн хариуцлагын даатгал	15%		
	Нийт			
2	Нөхөн төлбөрийн эрсдэл			
2.1	Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	20%		
2.2	Хөрөнгийн даатгал	60%		
2.3	Авто тээврийн хэрэгслийн даатгал	20%		
2.4	Ачааны даатгал	35%		
2.5	Барилга угсралтын даатгал	65%		
2.6	Газар тариалангийн даатгал	60%		
2.7	Мал амьтдын даатгал	60%		
2.8	Агаарын хөлгийн даатгал	60%		
2.9	Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	40%		
2.10	Хариуцлагын даатгал	35%		

2.11	Санхүүгийн даатгал	30%		
2.12	Зээлийн даатгал	35%		
2.13	Итгэлцлийн даатгал	60%		
2.14	Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	60%		
2.15	Жолоочийн хариуцлагын даатгал	20%		
Нийт				
Нийт андеррайтингийн эрсдэл				

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны ... дугаар сарын ...-ны өдрийн ... дүгээр тогтоолоор баталсан “Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ын зургаадугаар хавсралт

МАЯГТСЗХ04157. “.....” “ХХК-ийн 20... оны ..... дүгээр улирлын андеррайтингийн эрсдэлийн хамаарлын тооцоолол

Эрсдэлийн хамаарал	Хураамжийн эрсдэл	Нөхөн төлбөрийн эрсдэл
1. Хураамжийн эрсдэл	1	
2. Нөхөн төлбөрийн эрсдэл		1
Нийт эрсдэл		

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны ... дугаар  
сарын ....-ны өдрийн .... дүгээр тогтоолоор баталсан  
“Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур  
үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ын долоодугаар хавсралт

МАЯГТСЗХ04158. “..... “ ХХК-ийн 20... оны ..... дүгээр  
улирлын андеррайтингийн эрсдэлийн тооцоолол

№	Эрсдэл	Фактор	Нийт хураамж	ДД хураамж	Эрсдэл
1	<b>Нас баралтын эрсдэл</b>				
1.1	Хугацаат амьдралын даатгал	0.1%			
1.2	Насан туршийн даатгал	0.5%			
1.3	Хуримтлалын даатгал	0.3%			
1.4	Тэтгэврийн даатгал	0.3%			
1.5	Эрүүл мэндийн даатгал	0.0%			
1.6	Аннуити даатгал	0.3%			
	<b>Нийт</b>				
2	<b>Насжилтын эрсдэл</b>				
2.1	Хугацаат амьдралын даатгал	-0.2%			
2.2	Насан туршийн даатгал	-1.2%			
2.3	Хуримтлалын даатгал	-0.8%			
2.4	Тэтгэврийн даатгал	-0.8%			
2.5	Эрүүл мэндийн даатгал	-0.1%			
2.6	Аннуити даатгал	-0.8%			
	<b>Нийт</b>				
3	<b>Гэрээ цуцлалтын эрсдэл</b>				
3.1	Хугацаат амьдралын даатгал	9.0%			
3.2	Насан туршийн даатгал	30.0%			
3.3	Хуримтлалын даатгал	24.0%			
3.4	Тэтгэврийн даатгал	24.0%			
3.5	Эрүүл мэндийн даатгал	3.0%			
3.6	Аннуити даатгал	24.0%			
	<b>Нийт</b>				
4	<b>Зардлын эрсдэл</b>				
4.1	Хугацаат амьдралын даатгал	10.0%			
4.2	Насан туршийн даатгал	10.0%			
4.3	Хуримтлалын даатгал	10.0%			
4.4	Тэтгэврийн даатгал	10.0%			
4.5	Эрүүл мэндийн даатгал	10.0%			
4.6	Аннуити даатгал	10.0%			
	<b>Нийт</b>				

5	<b>Гамшгийн эрсдэл</b>				
5.1	Хугацаат амьдралын даатгал	0.3%			
5.2	Насан туршийн даатгал	0.3%			
5.3	Хуримтлалын даатгал	0.3%			
5.4	Тэтгэврийн даатгал	0.3%			
5.5	Эрүүл мэндийн даатгал	0.3%			
5.6	Аннуити даатгал	0.3%			
<b>Нийт</b>					

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны ... дугаар  
сарын ....-ны өдрийн .... дүгээр тогтоолоор баталсан  
“Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур  
үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ын наймдугаар хавсралт

МАЯГТСЗХ04159. “..... “ ХХК-ийн 20... оны ..... дүгээр  
улирлын андеррайтингийн эрсдэлийн хамаарлын тооцоолол

Эрсдэлийн хамаарал	Нас баралтын эрсдэл	Насжилтын эрсдэл	Гэрээ цуцлалтын эрсдэл	Зардлын эрсдэл	Гамшгийн эрсдэл
Нас баралтын эрсдэл	1.00				
Насжилтын эрсдэл		1.00			
Гэрээ цуцлалтын эрсдэл			1.00		
Зардлын эрсдэл				1.00	
Гамшгийн эрсдэл					1.00
Нийт эрсдэл					

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны ... дугаар  
сарын ....-ны өдрийн .... дүгээр тогтоолоор баталсан  
“Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур  
үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ын есдүгээр хавсралт

МАЯГТСЗХ04160. “..... “ ХХК-ийн 20... оны ..... дүгээр  
улирлын эрсдэлийн төрөлжүүлэлтийн бууралтын тооцоолол

Эрсдэлийн хамаарал	Зах зээлийн эрсдэл	Зээлийн эрсдэл	Андеррайтингийн эрсдэл
1.Зах зээлийн эрсдэл	1.00		
2.Зээлийн эрсдэл		1.00	
3.Андеррайтингийн эрсдэл			1.00
Нийт эрсдэл			

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдрийн ... дүгээр тогтоолоор баталсан  
“Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур  
үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ын аравдугаар хавсралт

МАЯГТСЗХ04161. “..... “ ХХК-ийн 20... оны ..... дүгээр  
улирлын хөрөнгийн хүрэлцээний харьцаа болон муу хөрөнгийн харьцааны тооцоолол

A	Даатгагчийн хөрөнгө	
<u>Нийт шаардлагатай хөрөнгө:</u>		
1	Зах зээлийн эрсдэл	
2	Зээлийн эрсдэл	
3	Андеррайтингийн эрсдэл	
4	Үйл ажиллагааны эрсдэл	
5	Нийт эрсдэл (1+2+3+4)	
6	Төрөлжүүлэлтийн бууралт	
7	Татварын хөнгөлөлт	
B	Эрсдэлд суурилсан хөрөнгө (5-6-7)	
C	Дүрмийн сан	
E	Нийт шаардлагатай хөрөнгө	
F	<u>Хөрөнгийн хүрэлцээний харьцаа A/E*100</u>	
G	Муу хөрөнгө	
H	Нийт хөрөнгө	
I	<u>Poor Assets Ratio</u> G / H * 100%	

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдрийн ... дүгээр тогтоолоор баталсан  
“Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур  
үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ын арван нэгдүгээр хавсралт

МАЯГТСЗХ04162. “..... “ ХХК-ийн 20... оны ..... дүгээр  
улирлын эрсдэлийн түвшин

Хөрөнгийн хүрэлцээний харьцаа/Муу хөрөнгийн харьцаа	< 100%	100-120%	120-150%	150-200%	>200%	
0-10%	Улбар шар-4	Улбар шар-5	Шар-6	Ногоон-7	Тод ногоон-8	↑↑↑ Тоо хэмжээ ↓↓↓
10-20%	Улаан-3	Улбар шар-4	Улбар шар-5	Шар-6	Ногоон-7	
20-50%	Хүрэн-2	Улаан-3	Улбар шар-4	Улбар шар-5	Шар-6	
>50%	Хар-1	Хүрэн-2	Улаан-3	Улбар шар-4	Улбар шар-5	
	→ → → → → ЧАНАР → → → → →					

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдрийн ... дүгээр тогтоолоор баталсан  
“Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур  
үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ын арван хоёрдугаар хавсралт

Хураамжийн эрсдэлийн коэффициент тооцоолол

	<b>Хураамжийн эрсдэл - beta тархалт</b>				
	Expected - Хохирлын харьцаа	Alpha	Beta	Var (99.5%) - Хохирлын харьцаа	Эрсдэлийн коэффициент
<b>Бүлэг 1 (Өндөр давтамжтай, бага эрсдэлтэй)</b>					
Жолоочийн хариуцлагын даатгал	56%	25.98	21.8	72%	16%
Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	11%	1.49	11.85	41%	30%
Авто тээврийн хэрэгслийн даатгал	52%	18.84	17.33	72%	20%
Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	36%	5.44	7.13	77%	41%
<b>Бүлэг 2 (Дундаж давтамжтай, дундаж эрсдэлтэй)</b>					
Ачааны даатгал	15%	1.78	10.21	48%	34%
Хариуцлагын даатгал	22%	1.73	5.97	67%	44%
Санхүүгийн даатгал	124%	1.67	0.39	164%	39%
Зээлийн даатгал	185%	3.32	0.44	255%	70%
<b>Бүлэг 3 (Давтамж бага, өндөр эрсдэлтэй)</b>					
Хөрөнгийн даатгал	21%	6.49	24.56	42%	21%
Барилга угсралтын даатгал	6%	0.42	0.44	75%	69%
Газар тариалангийн даатгал	81%	2.58	0.31	178%	97%
Мал амьтдын даатгал	32%	1.88	4.09	80%	49%
Агаарын хөлгийн даатгал	14%	0.96	2.28	90%	76%
Итгэлцлийн даатгал	2%	0.31	5.73	45%	43%
Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	5%	0.70	13.86	28%	23%

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдрийн ... дүгээр тогтоолоор баталсан  
“Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур  
үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ын арван гуравдугаар хавсралт

Нөхөн төлбөрийн эрсдэлийн коэффициент тооцоолол

Бүлэг 1 (Өндөр давтамжтай, бага эрсдэлтэй)	Нөхөн төлбөрийн эрсдэл - Normal тархалт				
	Expected - НТ-ийн нөөц сангийн өөрчлөлт	mu	sigma	Var (95%) - НТ-ийн нөөц сангийн өөрчлөлт	Эрсдэлийн коэффициент
Жолоочийн хариуцлагын даатгал	9%	0.09	0.1	25%	16%
Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	28%	0.28	0.26	71%	43%
Авто тээврийн хэрэгслийн даатгал	10%	0.1	0.07	22%	12%
Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	16%	0.16	0.11	34%	19%
<b>Бүлэг 2 (Дундаж давтамжтай, дундаж эрсдэлтэй)</b>					
Ачааны даатгал	20%	0.2	0.18	49%	29%
Хариуцлагын даатгал	14%	0.14	0.2	47%	33%
Санхүүгийн даатгал	19%	0.19	0.13	40%	22%
Зээлийн даатгал	23%	0.23	0.22	59%	36%
<b>Бүлэг 3 (Давтамж бага, өндөр эрсдэлтэй)</b>					
Хөрөнгийн даатгал	17%	0.17	0.13	39%	22%
Барилга угсралтын даатгал	50%	0.5	0.41	117%	67%
Газар тариалангийн даатгал	64%	0.64	0.56	156%	92%
Мал амьтдын даатгал	56%	0.56	0.33	111%	55%
Агаарын хөлгийн даатгал	100%	1	2.31	479%	380%
Итгэлцлийн даатгал	80%	0.8	0.36	140%	60%
Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	150%	1.5	1.96	473%	323%

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны ... дугаар сарын ...-ны өдрийн ... дүгээр тогтоолоор баталсан “Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ын арван дөрөвдүгээр хавсралт

Зах зээлийн эрсдэлийн ангилал, дансны жагсаалтаар

Хөрөнгийн ангилал	Дансны дугаар, тайлбар
Харилцах, хугацаагүй хадгаламж	1110, 1111, 1112, 1120, 1121, 1140, 1141, 1142, эдгээр дансанд тусгагдсан Монгол банкнаас банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, тусгай зөвшөөрөлтэй холбоотой аль нэг албадлагын арга хэмжээнд ороогүй, холбогдох этгээдэд үл хамаарах Банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2-д заасан шаардлагыг хангасан банкинд байршуулсан болон Гадаад улсын эрх бүхий байгууллагаас банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, тусгай зөвшөөрөлтэй холбоотой аль нэг албадлагын арга хэмжээнд ороогүй, холбогдох этгээдэд үл хамаарах “Стандарт энд Пурс” (Standard&Poor’s) компанийн BBB болон түүнтэй адилтгах зэрэглэлээс дээш зэрэглэлтэй банкинд байгаа харилцах, хадгаламжийн дүн
Санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулсан мөнгөн хөрөнгө	1130, 1131, 1332 эдгээр дансанд тусгагдсан Хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, тусгай зөвшөөрөлтэй холбоотой аль нэг албадлагын арга хэмжээнд ороогүй, холбогдох этгээдэд үл хамаарах Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийг хангасан банк бус санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгийн дүн
3 сараас 1 жилийн хугацаатай байршуулсан хөрөнгө	1310, 1311, 1312, 1317, 1318 эдгээр дансанд тусгагдсан Монгол банкнаас банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, тусгай зөвшөөрөлтэй холбоотой аль нэг албадлагын арга хэмжээнд ороогүй, холбогдох этгээдэд үл хамаарах Банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2-д заасан шаардлагыг хангасан банкинд, Хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, тусгай зөвшөөрөлтэй холбоотой аль нэг албадлагын арга хэмжээнд ороогүй, холбогдох этгээдэд үл хамаарах Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийг хангасан банк бус санхүүгийн байгууллагад болон Гадаад улсын эрх бүхий байгууллагаас банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, тусгай зөвшөөрөлтэй холбоотой аль нэг албадлагын арга хэмжээнд ороогүй, холбогдох этгээдэд үл хамаарах “Стандарт энд Пурс” (Standard&Poor’s) компанийн BBB болон түүнтэй адилтгах зэрэглэлээс дээш зэрэглэлтэй банкинд байршуулсан харилцах, хадгаламжийн дүн

1-5 жилийн хугацаатай байршуулсан хөрөнгө	1310, 1311, 1312, 1317, 1318 эдгээр дансанд тусгагдсан Монгол банкнаас банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, тусгай зөвшөөрөлтэй холбоотой аль нэг албадлагын арга хэмжээнд ороогүй, холбогдох этгээдэд үл хамаарах Банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2-д заасан шаардлагыг хангасан банкинд, Хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, тусгай зөвшөөрөлтэй холбоотой аль нэг албадлагын арга хэмжээнд ороогүй, холбогдох этгээдэд үл хамаарах Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийг хангасан банк бус санхүүгийн байгууллагад болон Гадаад улсын эрх бүхий байгууллагаас банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, тусгай зөвшөөрөлтэй холбоотой аль нэг албадлагын арга хэмжээнд ороогүй, холбогдох этгээдэд үл хамаарах “Стандарт энд Пурс” (Standard&Poor’s) компанийн BBB болон түүнтэй адилтгах зэрэглэлээс дээш зэрэглэлтэй банкинд байршуулсан харилцах, хадгаламжийн дүн
5-аас дээш жилийн хугацаатай байршуулсан хөрөнгө	1310, 1311, 1312, 1317, 1318 эдгээр дансанд тусгагдсан Монгол банкнаас банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, тусгай зөвшөөрөлтэй холбоотой аль нэг албадлагын арга хэмжээнд ороогүй, холбогдох этгээдэд үл хамаарах Банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2-д заасан шаардлагыг хангасан банкинд, Хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, тусгай зөвшөөрөлтэй холбоотой аль нэг албадлагын арга хэмжээнд ороогүй, холбогдох этгээдэд үл хамаарах Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийг хангасан банк бус санхүүгийн байгууллагад болон Гадаад улсын эрх бүхий байгууллагаас банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, тусгай зөвшөөрөлтэй холбоотой аль нэг албадлагын арга хэмжээнд ороогүй, холбогдох этгээдэд үл хамаарах “Стандарт энд Пурс” (Standard&Poor’s) компанийн BBB болон түүнтэй адилтгах зэрэглэлээс дээш зэрэглэлтэй банкинд байршуулсан харилцах, хадгаламжийн дүн
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө (валют)	1020, 1111, 1112 эдгээр дансанд тусгагдсан гадаад валютын дүн
Давхар даатгагчаас авах авлага	1230, 1239, 1240, 1249, 1250, 1259 эдгээр дансанд тусгагдсан давхар даатгагчаас авах авлагын дүн
Давхар даатгагчид өгөх өглөг	3150, 3151 эдгээр дансанд тусгагдсан давхар даатгагчид өгөх өглөг
Давхар даатгалын хойшлогдсон хураамж	1810 дансанд тусгагдсан Хорооноос баталсан даатгагч даатгалын гэрээгээр хүлээсэн эрсдэлээ давхар даатгуулах талаарх харилцааг зохицуулсан журамд заасан “зөвшөөрөгдөх давхар даатгагч”-тай байгуулсан давхар

	даатгалын гэрээний дагуу төлөх ёстой хойшлогдсон давхар даатгалын хураамжийн дүн
Нөхөн төлбөрийн нөөцийн давхар даатгагчид ногдох хэсэг	1820, 1821 эдгээр дансанд тусгагдсан нөхөн төлбөрийн нөөцийн давхар даатгагчид ногдох хэсгийн дүн
Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үнэт цаас	1320, 1321, 1323, 1327, 1328 эдгээр дансанд тусгагдсан хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үнэт цаасны дүн
Борлуулахад бэлэн хувьцаат компанийн үнэт цаас	1321, 1322, 1323, 1327, 1328 эдгээр дансанд тусгагдсан борлуулахад бэлэн хувьцаат компанийн үнэт цаасны дүн
Хугацааны эцэс хүртэл эзэмших хувьцаат компанийн үнэт цаас	1320, 1323, 1327, 1328 дансанд тусгагдсан хугацааны эцэс хүртэл эзэмших хувьцаат компанийн үнэт цаас
Хараат ба хамтын хяналттай, охин компаниудад оруулсан хөрөнгө оруулалт	1331, 1332, 1333, 1338, 1339 эдгээр дансанд тусгагдсан хараат ба хамтын хяналттай, охин компаниудад оруулсан хөрөнгө оруулалт
Үнэт металл, Дериватив	1350, 1351 эдгээр дансанд тусгагдсан үнэт металл, деривативын дүн
Газрын сайжруулалт	2010, 2061 эдгээр дансанд тусгагдсан дүн
Барилга байгууламж	2020, 2062 эдгээр дансанд тусгагдсан дүн
Машин тоног төхөөрөмж	2030, 2063 эдгээр дансанд тусгагдсан дүн
Тээврийн хэрэгсэл	2040, 2064 эдгээр дансанд тусгагдсан дүн
Тавилга эд хогшил	2050, 2065 эдгээр дансанд тусгагдсан дүн
Компьютер дагалдах хэрэгсэл	2060, 2066 эдгээр дансанд тусгагдсан дүн
Санхүүгийн түрээсийн хөрөнгө	2067, 2070 эдгээр дансанд тусгагдсан дүн

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны ... дугаар сарын ...-ны өдрийн ... дүгээр тогтоолоор баталсан “Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ын арван тавдугаар хавсралт

Зээлийн эрсдэлийн ангилал, дансны жагсаалтаар

Дотоодын банкин дахь харилцах, хугацаагүй хадгаламж	1110, 1111, 1120, 1121, 1140, 1141 эдгээр дансанд тусгагдсан Монгол банкнаас банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, тусгай зөвшөөрөлтэй холбоотой аль нэг албадлагын арга хэмжээнд ороогүй, холбогдох этгээдэд үл хамаарах Банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2-д заасан шаардлагыг хангасан банкинд байгаа харилцах, хадгаламжийн дүн
Даатгалын авлага	1210, 1219, 1220, 1229 эдгээр дансанд тусгагдсан даатгалын авлагын дүн.
Давхар даатгагчаас авах авлага	1230, 1239, 1240, 1249, 1250, 1259 эдгээр дансанд тусгагдсан давхар даатгагчаас авах авлагын дүн
Бусад авлага	1170, 1171, 1260, 1269, 1270, 1271, 1280, 1318, 1328, 2910, эдгээр дансанд тусгагдсан тохирох ангилал дахь авлагын дүн.
Банкны хадгаламж, хадгаламжийн сертификат	1310, 1311, 1317 эдгээр дансанд тусгагдсан Монгол банкнаас банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, тусгай зөвшөөрөлтэй холбоотой аль нэг албадлагын арга хэмжээнд ороогүй, холбогдох этгээдэд үл хамаарах Банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2-д заасан шаардлагыг хангасан банкинд байршуулсан болон Гадаад улсын эрх бүхий байгууллагаас банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, тусгай зөвшөөрөлтэй холбоотой аль нэг албадлагын арга хэмжээнд ороогүй, холбогдох этгээдэд үл хамаарах “Стандарт энд Пурс” (Standard&Poor’s) компанийн BBB болон түүнтэй адилтгах зэрэглэлээс дээш зэрэглэлтэй банкинд байгаа харилцах, хадгаламжийн дүн
Давхар даатгалын хойшлогдсон хураамж	1810 дансанд тусгагдсан Хорооноос баталсан даатгагч даатгалын гэрээгээр хүлээсэн эрсдэлээ давхар даатгуулах талаарх харилцааг зохицуулсан журамд заасан “зөвшөөрөгдөх давхар даатгагч”-тай байгуулсан давхар даатгалын гэрээний дагуу төлөх ёстой хойшлогдсон давхар даатгалын хураамжийн дүн
Нөхөн төлбөрийн нөөцийн давхар даатгагчид ногдох хэсэг	1820, 1821 эдгээр дансанд тусгагдсан нөхөн төлбөрийн нөөцийн давхар даатгагчид ногдох хэсгийн дүн
Засгийн газраас гаргасан өрийн хэрэгсэл	115001, 115101, 132001, 132101, 132201, 132301, 132601, 132701, 132901 эдгээр дансанд тусгагдсан Монгол Улсын засгийн газрын өрийн хэрэгслийн дүн

Төв банкны үнэт цаас	115002, 115102, 132002, 132102, 132202, 132302, 132602, 132702, 132901 эдгээр дансанд тусгагдсан Монголбанкны мөнгөний бодлогын нээлттэй захын хэрэгсэл бөгөөд хямдруулса хэлбэрээр арилжигдаж, тогтоосон хугацааны дараа нэрлэсэн үнээр эргэн төлөгдөх үнэт цаасны дүн
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	132003, 132103, 132203, 132303, 132603, 132703, 132901 эдгээр дансанд тусгагдсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан хөрөнгийн дүн
Аймаг нийслэлийн гаргасан өрийн хэрэгсэл	132004, 132104, 132204, 132304, 132604, 132704, 132901 эдгээр дансанд тусгагдсан аймаг нийслэлийн гаргасан өрийн хэрэгслийн дүн
Компанийн өрийн хэрэгсэл	132005, 132105, 132205, 132305, 132605, 132705, 132805, 132901 эдгээр дансанд тусгагдсан Үнэт цаасны зах зээлд арилжаалагддаг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.9-т заасан, Хорооноос тусгай зөвшөөрөл авсан даатгагчийн холбогдох этгээдээс бусад компанийн өрийн хэрэгслийн дүн
Монголын хөрөнгийн биржийн хувьцаат компанийн хувьцаа – 1 ангилал	132106, 132206, 132306, 132606, 132706, 132806, 132901 эдгээр дансанд тусгагдсан уг ангиллаарх хөрөнгийн дүн
Монголын хөрөнгийн биржийн хувьцаат компанийн хувьцаа – 2 ангилал	132107, 132207, 132307, 132607, 132707, 132807, 132901 эдгээр дансанд тусгагдсан уг ангиллаарх хөрөнгийн дүн
Хөрөнгө оруулалтын нээлттэй сан	132009, 132109, 132209, 132309, 132609, 132709, 132901 эдгээр дансанд тусгагдсан уг ангиллаарх Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 6.2.1-д заасан хөрөнгийн дүн
Хөрөнгө оруулалтын хаалттай сан	132009, 132109, 132209, 132309, 132609, 132709, 132809, 132901 эдгээр дансанд тусгагдсан уг ангиллаарх Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 6.2.1-д заасан хөрөнгийн дүн
Гадаадын Засгийн газраас гаргасан өрийн хэрэгсэл	115001, 115101, 132201, 132301, 132601, 132701, 132901 эдгээр дансанд тусгагдсан олон улсын хөрөнгийн биржүүд дээр арилжаалагдаж байгаа “Стандарт энд Пурс” (Standard&Poog’s) компанийн ВВВ болон түүнтэй адилтгах зэрэглэлээс дээш зэрэглэлтэй Гадаадын засгийн газраас гаргасан өрийн хэрэгслийн дүн
Гадаадын Төв банкны үнэт цаас	132202, 132302, 132602, 132702, 132901 эдгээр дансанд тусгагдсан олон улсын хөрөнгийн биржүүд дээр арилжаалагдаж байгаа “Стандарт энд Пурс” (Standard&Poog’s) компанийн ВВВ болон түүнтэй адилтгах зэрэглэлээс дээш зэрэглэлтэй Гадаадын Төв банкны үнэт цаасны дүн

<p>Гадаадын компанийн өрийн хэрэгсэл</p>	<p>132205, 132305, 132605, 132705, 132901 эдгээр дансанд тусгагдсан Хорооноос баталсан Ердийн даатгалын компанийн даатгалын нөөц сангаас хөрөнгө оруулалт хийх талаарх харилцааг зохицуулсан эрх зүйн актад заасан олон улсын хөрөнгийн биржүүд дээр арилжаалагдаж байгаа “Стандарт энд Пурс” (Standard&amp;Poor’s) компанийн BBB болон түүнтэй адилтгах зэрэглэлээс дээш зэрэглэлтэй холбогдох этгээдэд үл хамаарах Гадаадын компанийн өрийн хэрэгслийн дүн</p>
<p>Гадаадын компанийн хувьцаа</p>	<p>132210, 132310, 132610, 132710, 132901 эдгээр дансанд тусгагдсан 132205, 132305, 132605, 132705, 132901 эдгээр дансанд тусгагдсан Хорооноос баталсан Ердийн даатгалын компанийн даатгалын нөөц сангаас хөрөнгө оруулалт хийх талаарх харилцааг зохицуулсан эрх зүйн актад заасан олон улсын хөрөнгийн биржүүд дээр арилжаалагдаж байгаа “Стандарт энд Пурс” (Standard&amp;Poor’s) компанийн BBB болон түүнтэй адилтгах зэрэглэлээс дээш зэрэглэлтэй холбогдох этгээдэд үл хамаарах Гадаадын компанийн хувьцааны дүн</p>

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны ... дугаар сарын ...-ны өдрийн ... дүгээр тогтоолоор баталсан “Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ын арван зургаадугаар хавсралт

## **ДААТГАГЧ ӨӨРИЙН ЭРСДЭЛ БОЛОН ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭЭ ҮНЭЛЭХ ЗААВАР**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1 Энэ зааврын зорилго нь даатгагч учирч болзошгүй эрсдэлээ тодорхойлох, хэмжих, зохистойгоор удирдах, хянах, тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2 Даатгагч үндсэн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхтэй холбоотой үүсэх эрсдэлийг удирдах зорилгоор Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/-ийн баталсан Эрсдэлийн удирдлагын стратегитай байна. Даатгагч нь эхний ээлжинд өөрийн бизнесийн зорилт болон байгаа боломжит нөөцөө харгалзан дааж чадахуйц эрсдэл буюу эрсдэл даах чадвараа тодорхойлох шаардлагатай.

1.3 Даатгагч Эрсдэлийн удирдлагын стратегиа боловсруулахдаа дараах асуудлыг судалсан байна:

1.3.1 эдийн засаг, зах зээлийн төсөөлөл, тэдгээрээс даатгагчийн үйл ажиллагаанд үзүүлэх сөрөг үр дагавар болон нөлөөлөл;

1.3.2 зах зээлийн тодорхой сегмент дэх бизнесийн зорилгодоо хүрэх болон тухайн эрсдэлүүдийг таних, хэмжих, хянах боловсон хүчний нөөц;

1.3.3 эрхэлж буй даатгалын төрөл, хэлбэр, төвлөрлийн байдал.

1.4 Даатгагч нь тодорхой хугацааны давтамжтайгаар өөрийн санхүүгийн байдал болон зах зээлийн хөгжлийн нөхцөл байдлыг харгалзан Эрсдэлийн удирдлагын стратегиа дахин эргэж судалж байх шаардлагатай. Даатгагчийн үйл ажиллагаа, бизнесийн стратегид томоохон өөрчлөлт гарсан бол Эрсдэлийн удирдлагын стратегиа мөн өөрчлөх эсэх талаар судалж үзэх нь зүйтэй.

1.5 ТУЗ-ийн баталсан Эрсдэлийн удирдлагын стратегиас зөрсөн гэнэтийн өөрчлөлтийн талаар хяналт баталгаажилтын үйл ажиллагаа заавал байх шаардлагатай ба энэхүү стратегид өөрчлөлт орсон тохиолдолд ТУЗ-өөр хэлэлцүүлж, батлуулна.

1.6 Даатгагч энэ зааврын 1.2-т заасан Эрсдэлийн удирдлагын стратегийг анх батлуулах болон түүнд өөрчлөлт оруулсан тохиолдолд ТУЗ-өөр батлуулснаас хойш 14 хоногийн дотор Хороонд хүргүүлнэ.

### **Хоёр. Даатгагчийн өөрийн эрсдэл болон төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн үнэлгээ хийх аргачлал, түүнд тавигдах шаардлага**

2.1 Даатгагч нь энэ зааврын дагуу өөрийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, Эрсдэлийн удирдлагын стратегид тохирохуйц бизнесийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийн онцлог, цар хүрээ, харилцан хамааралтай шинж чанарыг харгалзан хамгийн тохиромжтой, хангалттай аргачлал, техникийг багтаасан эрсдэл болон төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг үнэлэх аргачлал /цаашид “үнэлгээний аргачлал”/-тай байна.

2.2 Энэ зааврын 2.1-д заасан үнэлгээний аргачлалыг даатгагчийн ТУЗ батлах ба үнэлгээний аргачлалд дараах зүйлсийг заавал тусгана:

2.2.1 Эрсдэлийн соёл ба засаглал: Засаглалын бүтэц нь эрсдэлд суурилсан шийдвэр гаргалтын ил тод, хариуцлагатай байдлыг дэмжих эрсдэлийн соёл болон үйл ажиллагаан дахь үүрэг, хариуцлага, тайлагналыг тодорхойлж, тусгасан байх шаардлагатай. Мэдээллийн чанарын асуудлыг энэ хэсэгт тусгана.

2.2.2 Эрсдэлийг тодорхойлж, эрэмбэлэх: Энэ процесс нь байгууллагын хамгийн чухал процесс бөгөөд үйл ажиллагаа бүрийн хариуцагч нь ойлгомжтой тодорхойлогдсон, эрсдэлийн удирдлагын үүрэг, функц нь байгууллагын бүхий л түвшинд тохиромжтой тодорхойлогдсон эсэхийг баталгаажуулсан байх.

2.2.3 Эрсдэл хүлээж авах сонирхол, эрсдэл үүрэх болон түүний хязгаар: Даатгагчийн хувьд эрсдэл хүлээн авах сонирхлын шийдвэр, холбоотой эрсдэлийн үүрэх хязгаар зэрэг нь эрсдэлийн удирдлагын хамгийн чухал үзүүлэлт юм. ТУЗ нь эрсдэл хүлээж авах сонирхлын шийдвэр нь эрсдэлийн стратегитэй нийцэж буй эсэхийг хянаж үзэх шаардлагатай.

2.2.4 Эрсдэлийн удирдлага ба хяналт: Эрсдэлийг удирдах нь байгууллагын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж буй хэлбэр бөгөөд байгууллагын дотор бүхий л түвшинд хэрэгжинэ. Даатгагч өөрийн үйл ажиллагааны шинж чанар, хэмжээнээс хамаарсан эрсдэлийн удирдлагын бүтэцтэй байх шаардлагатай. Энэхүү бүтэц нь эрсдэлийн үр ашигтай удирдлага, эрсдэлийн хяналт явуулах боломж, чадавхитай байна.

2.2.5 Эрсдэлийн тайлагнал ба харилцан холбоо: Эрсдэлийн удирдлагын процессыг ил тод байлгах хамгийн чухал шалгуур, үзүүлэлтүүдийг тогтоох, эрсдэлийн удирдлага болон эрсдэл хүлээж авахтай холбоотой шийдвэрүүдийг хэрхэн гаргах талаар, мөн үнэлгээ хийх давтамжийг тусгах.

2.3 Даатгагч үнэлгээний аргачлалд дараах эрсдэл тус бүрийг тооцоолж, хэрхэн удирдах бодлого, стратегийг байгууллагын эрсдэлийн удирдлагын бодлоготой уялдуулан боловсруулсан байна.

2.3.1 Үнэт цаас гаргагч, зээлдэгч, зуучлагч, даатгуулагч, давхар даатгагч болон баталгаа гаргагч зэрэг гуравдагч тал буюу харилцагчид төлбөрийн чадваргүй болох, гэрээний хариуцлагаа биелүүлэх боломжгүй болсны улмаас даатгагчид учирч болох эрсдэл буюу “Зээлийн эрсдэл”.

2.3.2 Зах зээлийн үнэ ба түвшинд өөрчлөлт орсноос үүдэн санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ болон ирээдүйн мөнгөн гүйлгээ хэлбэлзэх эрсдэл буюу “Ханш ба үнийн эрсдэл”. Үүнд хүүгийн түвшний эрсдэл, валютын ханшийн эрсдэл болон бусад үнийн эрсдэл зэрэг хамаарна.

2.3.3 Даатгалын бүтээгдэхүүний загвар ба үнэ тогтоолтын эрсдэл болон андеррайтинг ба хариуцлагын эрсдэл. Даатгалын бүтээгдэхүүний загвар ба үнэ тогтоолтын эрсдэл нь даатгалын үнэ тогтооход таамаглаж байсан хүлээлтээс даатгалын өртөг зардал, хариуцлага хэтрэх тохиолдол зэрэг даатгалын үйл ажиллагааны улмаас даатгагчид санхүүгийн хохирол үүсэхэд бий болдог эрсдэл буюу буюу “Даатгалын эрсдэл”. Андеррайтинг ба хариуцлагын эрсдэл нь даатгагчийн эрсдэлийг сонгох, хүлээж авах, бууруулах, авч үлдэх, шилжүүлэх болон даатгалын бүтээгдэхүүний удирдлагатай холбоотойгоор даатгагчид санхүүгийн хохирол учрах эрсдэл.

2.3.4 Бизнесийн үйл ажиллагааны зохион байгуулалт болон байгууллагын чиг үүргээс шалтгаалан бий болох эрсдэл буюу “Үйл ажиллагааны эрсдэл”. Үүнд дотоод хяналтын үйл ажиллагааны дутагдал, технологийн уналт, хувь хүн, ажилтнуудын алдаа болон үндэсний хэмжээний гамшиг сүйрэл хамаарна.

2.3.5 Даатгагч Даатгалын тухай хуулийн 2.1-т заасан даатгалын тухай хууль тогтоомжийг мөрдөөгүйн улмаас үүдэн гарах эрсдэл буюу “Хууль, зохицуулалтын хүрээний эрсдэл”.

2.3.6 Даатгагчийн бизнес төлөвлөгөө, стратеги төлөвлөгөө, шийдвэр гаргалт, нөөцийн хуваарилалтыг тохиромжтой байдлаар хэрэгжүүлээгүй болон бизнесийн орчинд гарсан өөрчлөлтөд дасан зохицох боломжгүй болсон тохиолдолд үүсэх эрсдэл буюу “Стратегийн эрсдэл”.

2.3.7 Компанийн нэгдэлд багтах компаниуд төлбөрийн чадваргүй болох, даатгагчтай хийгдсэн гүйлгээнүүд нь төлөгдөх боломжгүй болсноос үүдэн гарах эрсдэл буюу “Холбоотой талуудын эрсдэл”.

2.4 Даатгагч өөрийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийн онцлог, хүрээ, нарийн төвөгтэй байдал зэргээс хамааруулан энэ зааврын 2.3-т зааснаас өөр эрсдэлийг хамааруулж болно.

2.5 Даатгагчийн санхүүгийн үзүүлэлтийн үнэлгээг хийхдээ даатгагчийн хөрөнгийн чадвартай уялдуулахаас гадна даатгалын нөөц сангийн хүртээмжтэй, хангалттай байдлыг харгалзан үзнэ.

2.6 Даатгагч нь компанийн нэгдэлд багтдаг бол компанийн нэгдлийн түвшинд үнэлгээ хийх аргачлалыг багтаана.

2.7 Даатгагч энэ зааврын 2.1-д заасан үнэлгээний аргачлал, түүнд орох өөрчлөлтийг ТУЗ-өөр батлуулах ба баталснаас хойш 14 хоногийн дотор Хороонд ирүүлнэ.

2.8 Даатгагч нь энэ зааврын 2.1-д заасан үнэлгээний аргачлалыг дараа онд дагаж мөрдөх эсэх талаар, мөрдөхөөргүй бол холбогдох тайлбар, мэдээллийг өмнөх оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Хороонд ирүүлнэ.

### **Гурав. Даатгагчийн өөрийн эрсдэл болон төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн үнэлгээ хийх, үнэлгээний тайлан**

3.1 Даатгагч өөрийн эрсдэл болон төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн үнэлгээ хийх эрсдэлийн менежертэй байна.

3.2 Даатгагч энэ зааврын 2 дугаар бүлэгт заасан үнэлгээний аргачлалын дагуу үнэлгээг улирал бүр хийж өөрийн эрсдэл болон төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн үнэлгээний тайлан /цаашид “үнэлгээний тайлан” гэх/-г гаргах бөгөөд үнэлгээний тайланд нэмж үзүүлэлт оруулах боломжтой.

3.3 Даатгагч үнэлгээний тайланд дараах зүйлсийг хавсаргана:

3.3.1 Даатгалын компанийн ерөнхий үзүүлэлт: Энэхүү үзүүлэлт нь байгууллагын удирдлага, ТУЗ болон хувьцаа эзэмшигчдийн бүтэц, зохион байгуулалттай холбоотой асуудлуудыг хамруулна.

3.3.2 Эрсдэлийн удирдлагын стратеги: Энэхүү үзүүлэлт нь компанийн эрсдэлийн удирдлага болон өөрийн гүйцэтгэлтэй шууд холбогдох ба компани эрсдэлээ хэрхэн илрүүлж, үнэлж байгаа процесс болон түүнийг бууруулах, хянах механизм болон хөрөнгийн хангалттай байдлыг хянаж байгаа үйл явцаас хамаарна.

3.3.3 Даатгагчийн хувийн хэрэгт орсон өөрчлөлт: Тухайлбал даатгагчийн санхүүгийн нөхцөл байдал, эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийн түвшин болон бусад томоохон өөрчлөлт гарсан эсэх асуудлыг хамруулна.

3.3.4 Үйл ажиллагааны нөлөөлөл: Тайлант үед гарсан томоохон өөрчлөлт нь ирээдүйд компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн байдалд нөлөөлөх эсэх талаар асуудлыг хамруулна.

3.3.5 Санхүүгийн шинжилгээ: Даатгагч нь шуурхай шинжилгээг “Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ын 16 дугаар хавсралтаар, эрт анхааруулах шинжилгээг тус журмын 17 дугаар хавсралтын дагуу гаргана.

3.3.6 Даатгагчийн санхүүгийн төсөв, төлөвлөгөөнд хийсэн дүгнэлт: Даатгагчийн санхүүгийн төлөвлөгөө, төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулсан эсэх, түүнд өөрчлөлт орсон эсэх, энэ нь цаашид эрсдэл дагуулах эсэх асуудлыг хамруулна.

3.3.7 Даатгагч өөрийн бизнес төлөвлөгөөнд хийсэн дүгнэлт: Даатгагчийн бизнес төлөвлөгөө нь хэр бодитой боловсруулагдсан болон бизнес төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа явуулж байгаа эсэх, мөн бизнес төлөвлөгөөг санхүүжүүлэх хэмжээний хөрөнгө даатгагчид байгаа эсэх, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай удирдлага, ажиллах хүч байгаа эсэх гээд ерөнхийд нь бизнес төлөвлөгөө хэрэгжих боломжтой эсэх асуудлыг хамруулна.

3.3.8 Аудиторын тайлангийн хэрэгжилт.

3.4 Даатгагчийн үнэлгээний тайланд даатгагчийн дотоод хяналтын алба нь хяналт шалгалт хийж, дүгнэлт боловсруулна.

3.5 Даатгагч үнэлгээний тайланг даатгагчийн дотоод хяналтын дүгнэлтийн хамт дараа оны 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор Хороонд ирүүлнэ.

3.6 Даатгагч нь өөрийн эрсдэл болон төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн үнэлгээний тайлантай холбоотойгоор даатгагчийн бизнес төлөвлөгөө болон андеррайтинг, давхар даатгал, хөрөнгийн удирдлагатай холбогдох төлөвлөгөө, баримт бичигт өөрчлөлт оруулах тохиолдолд энэ талаар үнэлгээний тайланд заавал тусгаж, эдгээр баримт бичигт холбогдох өөрчлөлтийг оруулна.

3.7 Даатгагч макро, микро эдийн засгийн хүчин зүйл, даатгагчийн бизнесийн стратеги болон бусад гадаад, дотоод орчны өөрчлөлтөөс үүдэн даатгагчид үүсч болзошгүй эрсдэлийг стресс тест, эмзэг байдлын шинжилгээ, урвуу стресс тест болон бусад шинжилгээний арга аргачлалыг ашиглан дүгнэлт хийсэн байх шаардлагатай.

3.8 Даатгагч нь төлбөрийн чадварын зохистой шалгуур үзүүлэлт болон даатгалын нөөц сангийн хүрээнд зохицуулагчаас тавьж буй хөрөнгийн шаардлагыг хангаж ажиллаж байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж, холбогдох шинжилгээг хийж ажиллах ба үүнд дараах зүйлсийг заавал шалгана:

3.8.1 Даатгагчийн эрсдэлийн багцад орж болзошгүй ирээдүйн материаллаг өөрчлөлт;

3.8.2 Даатгагчийн бизнес төлөвлөлтийн бүхий л шатыг санхүүжүүлэх хөрөнгийн чанар, тоо хэмжээ;

3.8.3 Даатгагчийн хөрөнгийн төрлийн бүрдэл, үүнд бизнесийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарах төлбөр тооцоо, хугацаанд гарах өөрчлөлт нь хэрхэн нөлөөлж болох талаар үнэлгээ хийх;

3.8.4 Нөөц сангийн тооцоололд тавигдах шаардлагыг даатгагч тогтмол хангаж байгаа эсэх талаарх мэдээлэл;

3.8.5 Нөөц сангийн тооцоололтой холбоотойгоор гарч болзошгүй боломжит эрсдэлийг тодорхойлох.

3.9 Даатгагч энэ зааврын 3.7-д заасан шинжилгээг хийх явцад даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон даатгалын нөөц санд холбогдох эрсдэл үүссэн тохиолдолд энэ талаар Хороонд нэн даруй мэдэгдэнэ.

3.10 Хорооны Хяналт шалгалт хариуцсан нэгж нь даатгагчдын эрсдэлийн түвшингийн үнэлгээг нэгтгэн, газар дээрх хяналт шалгалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах эсэхийг шийдвэрлэнэ.

3.11 Даатгагчийн санхүүгийн чадварын үзүүлэлт нь компанийн хөрөнгийн чадвартай уялдахаас гадна даатгалын нөөц сангийн хүртээмжтэй, хангалттай байдлаас шалтгаална.

### **Дөрөв. Хяналт, хариуцлага**

4.1 Даатгагчийн ирүүлсэн үнэлгээний аргачлал болон үнэлгээний тайлан нь Хорооноос даатгагчид хийх хяналт шалгалтын үндсэн баримт бичиг болох бөгөөд үүнтэй холбогдуулан Хороо хэдийд ч нэмэлт материал шаардаж болно.

4.2 Даатгагчийн үнэлгээний аргачлал болон үнэлгээний тайлан, тэдгээрийг боловсруулахад ашигласан мэдээллийн үнэн зөв эсэхийг даатгагч хариуцах бөгөөд тэдгээрийн чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор Хороо зөвлөмж хүргүүлж болно.

--oOo--

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдрийн ... дүгээр тогтоолоор баталсан  
“Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур  
үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ын арван долоодугаар хавсралт

Даатгагчийн өөрийн эрсдэл болон төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур  
үзүүлэлтийн үнэлгээний тайлан

Бүлэг		Товч тайлбар
А	Ерөнхий танилцуулга	<ul style="list-style-type: none"> <li>• Үнэлгээний тайлангийн зорилго</li> <li>• Үнэлгээний тайланд тусгагдсан төлөвлөгөөний хамрах хүрээ</li> <li>• Үнэлгээний үр дүнгийн тойм</li> <li>• Даатгагчийн санхүүгийн чадавхид нөлөөлөх гол эрсдлүүд болон тэдгээрийн нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд</li> </ul>
Б	Үнэлгээний процесс	<ul style="list-style-type: none"> <li>• Үнэлгээний процессын товч танилцуулга</li> <li>• Эрсдлийн профайлыг удирдах бодлогуудын үр нөлөөний талаархи тайлбар болон эрсдлийн удирдлагын гол бодлогын хураангуй</li> <li>• Үнэлгээний процесс болон суурь таамаглал(төсөөлөл)-ын хураангуй</li> <li>• Үндсэн төсөөллийн дэлгэрэнгүй болон голлох төсөөллүүдийн хоорондох харилцан хамаарал</li> </ul>
В	Стратеги ба эрсдэл даах чадвар	<ul style="list-style-type: none"> <li>• Өнөөгийн бизнес стратеги болон эрсдэл даах чадварын талаар</li> <li>• Бизнесийн стратегийн эрсдлийн профайлд үзүүлэх нөлөөлөл</li> <li>• Стратеги, эрсдэл, хөрөнгийн хоорондын уялдаа холбоог харуулсан байх</li> </ul>
Г	Эрсдэлд өртөх байдал	<ul style="list-style-type: none"> <li>• Тодорхойлогдсон эрсдлийг хэрхэн давах талаарх одоогийн эрсдэлийн профайлын үнэлгээ болон эрсдэл даах чадварын тайлан</li> <li>• Эдийн засгийн хөрөнгө болон зохицуулалтын хөрөнгийн хяналтын хүрээнд тооцоолох боломжгүй эрсдлийг үнэлэх (тухайлбал группын, нэр хүндийн болон шинээр гарч ирж болзошгүй эрсдэл)</li> <li>• Гол эрсдлийг бууруулахад тавигдах хяналтын үр дагаварын үнэлэлт</li> <li>• Сүүлийн тайлангаас хойш эрсдэл даах чадварын тооцоололд гарсан алдаа болон эрсдлийн стратеги, хөрөнгөнд үзүүлэх аливаа нөлөөлөл байгаа эсэх</li> </ul>

Д	Бизнес төлөвлөгөө болон стресс тест хийх	<ul style="list-style-type: none"> <li>• Стресс тест, эмзэг байдлын шинжилгээний хураангуй</li> <li>• Таамаглалд авч үзсэн үзүүлэлтүүдийн тайлбар болон стресс тестийн бүтэц, түүнийг сонгосон үндэслэл</li> <li>• Төрөл бүрийн нөхцлөөр тооцоолсон боломжит эрсдэл, хөрөнгө, төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн профайл</li> <li>• Үр дүнгийн чанар (хэрэв байгаа бол)</li> </ul>
Е	Хөрөнгийн шаардлага	<ul style="list-style-type: none"> <li>• Шаардлагатай хөрөнгийг тодорхойлох аргачлалын тойм</li> <li>• Учирсан бодит болон болзошгүй эрсдэлд тулгуурласан шаардлагатай хөрөнгийн тооцоолол</li> <li>• Санхүү, эдийн засаг, өөрийн хөрөнгийн зохистой байдлын өөрчлөлтийн гол нөлөө үзүүлэгч хүчин зүйлийн шинжилгээ</li> </ul>
Ё	Төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийн тооцоолол	<ul style="list-style-type: none"> <li>• Өнөөгийн болон ирээдүйн төсөөлөл дээр үндэслэсэн шаардлагатай хөрөнгөнд нийцүүлсэн санхүүгийн үнэлгээ</li> <li>• Төлөвлөсөн санхүүжилт нь ирээдүйн хэрэгцээтэй хөрөнгийг хангаж чадахгүй тохиолдолд авах арга хэмжээний төлөвлөгөө, эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа</li> <li>• Шаардлагатай тохиолдолд болзошгүй эрсдэлийн дараах үйл явдалд зориулсан нэмэлт санхүүжилтийг олох боломж (жишээ нь, толгой компаний зүгээс)</li> <li>• Хөрөнгийн үр ашигтай байдал болон чанарт үнэлгээ өгөх</li> </ul>
Ж	Баталгаатай байдал	<ul style="list-style-type: none"> <li>• Өмнөх жилийн төсөөллийг бодит тохиолдолтой харьцуулалт хийж үнэлэлт, дүгнэлт өгөх (хөрөнгийн хүрэлцээний шаардлагыг оруулаад)</li> <li>• Өмнөх үнэлгээний тайланд тусгагдсан зөвлөмжийн дагуу удирдлагаас авсан арга хэмжээний талаар</li> <li>• Үнэлгээнд өгсөн хөндлөнгийн үнэлгээ (хэрвээ байгаа бол)</li> <li>• Хязгаарлалт ба хамаарал</li> </ul>
З	Хавсралт, тайлбар	Стресс тестийн дэлгэрэнгүй төсөөлөл

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдрийн ... дүгээр тогтоолоор баталсан  
“Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур  
үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ын арван наймдугаар хавсралт

**ДААТГАГЧИЙН ШУУРХАЙ ШИНЖИЛГЭЭ**

Даатгагчийн нэр.....

20...оны ... сарын ...-ны өдөр

	Шинжилгээний зорилго	Үзүүлэлт	Тооцох журам	Өмнөх оны тайлант үе	Тайлант оны улирал
1	Хөрөнгийн байдлын үнэлгээ	1. Үндсэн хөрөнгийн нийт хөрөнгөд эзлэх хувь 2. Хөрөнгийн элэгдэл  3. Нийт хөрөнгийн өсөлт	1. Үндсэн хөрөнгө/Нийт хөрөнгө*100%  2. Хур.элэгдэл/ Биет ба биет бус хөрөнгийн анхны өртөг*100% 3. Оны эхний нийт хөрөнгө/оны эцсийн нийт хөрөнгө*100%		
2	Санхүүгийн байдлын үнэлгээ	1. Өөрийн хөрөнгийн хувийн жин 2. Эргэлтийн харьцаа  3. УХӨТ-ийн нийт эх үүсвэр эзлэх %-ийн жин 4. Нөөц сангийн нийт эх үүсвэрт эзлэх хувийн жин	1. Өөрийн хөрөнгө/Нийт эх үүсвэр *100% 2. Эргэлтийн хөрөнгө/БХӨТ 3. УХӨТ/Нийт эх үүсвэр*100% 4. Нөөц сан/Нийт эх үүсвэр		
3	Ашигт ажиллагааны үнэлгээ	1. Цэвэр ашгийн өөрчлөлт 2. Нийт ашгийн түвшин  3. Үйл ажиллагааны ашгийн түвшин  4. Өөрийн хөрөнгийн ашигт ажиллагаа 5. Даатгагчид үлдэх хураамжийн хувь  6. Даатгалын цэвэр ашгийн хувь 7. Нийт хөрөнгийн ашигт ажиллагаа	1. ЦА абсолют хэлбэлзэл 2. Нийт ашиг/Орлогод тооцсон хураамж (Даатгалын цэвэр орлого) 100% 3. Үйл ажиллагааны ашиг/Даатгалын хураамжийн орлого*100% 4. Цэвэр ашиг/Өөрийн хөрөнгө 5. Даатгалын цэвэр орлого/ Нийт даатгалын орлого 6. Цэвэр ашиг/Орлогод тооцсон хураамж		

			(Даатгалын цэвэр орлого) 7. Цэвэр ашиг/Нийт хөрөнгө		
4	Даатгалын үйл ажиллагааны шинжилгээ	<p>Даатгалын үнэлгээний хүртээмж, хураамж үнэ тогтоолт хэрхэн хийгдсэнийг тогтооход чиглэгдэнэ.</p> <p>1.Хохирлын харьцаа</p> <p>2.Зардлын харьцаа</p> <p>3.Хосолсон харьцаа</p> <p>4.Үйл ажиллагааны харьцаа</p> <p>Даатгалын төвлөрлийн үзүүлэлтийг даатгалын эрсдэлийн газар зүйн байрлал болон бусад хүчин зүйлээр нь авч үзнэ.</p>	<p>1. Нийт нэхэмжлэл /орлогод тооцсон хураамж (Даатгалын цэвэр орлого)</p> <p>2. Үйл ажиллагааны зардал/ орлогод тооцсон хураамж (Даатгалын цэвэр орлого)</p> <p>3.Хохирол нөхөлтийн харьцаа+ зардлын харьцаа</p> <p>4.Хөрөнгө оруулалтын орлогоор тохируулга хийгдсэн холимог харьцаа буюу холимог харьцаан дах орлого тооцсон хураамж (Даатгалын цэвэр орлого) дээр хөрөнгө оруулалтын орлогыг нэмнэ.</p> <p>Хэрэв үйл ажиллагааны харьцаа 100 хувиас хэтрэх, хураамжийн орлого, хохирол болон зардлын түвшин тараан байршуулсан хөрөнгөөс хэтэрсэн тохиолдолд хөрөнгө оруулсан хөрөнгийн</p>		

		6-8 Өөрийн хөрөнгийн хүрэлцээ	<p>өгөөжид сөргөөр нөлөөлнө.</p> <p>6. Дүрмийн сан/хураамжийн орлого</p> <p>7. Дүрмийн сан/ нөөц сан</p> <p>8. Дүрмийн сан/нөхөн төлбөр</p>		
5	Мэдрэмжийн шинжилгээ	Мэдрэмтгий байдал	<p>1. Нөхөн төлбөрийн 1 хувийн өөрчлөлтөөс эздийн өмчид үзүүлэх нөлөөлөл</p> <p>2. Инфляцийн түвшний 10 хувийн өөрчлөлтийн даатгалын өр төлбөрт үзүүлэх нөлөөлөл,</p> <p>3. Хүүгийн түвшний 10 хувийн өөрчлөлтийн хөрөнгөд үзүүлэх нөлөөллүүд, хөнгөлтэй үед</p> <p>4. Хүүгийн түвшний 10 хувийн өөрчлөлтийн даатгалын өр төлбөрт үзүүлэх нөлөөллүүдийг тооцно.</p>		

6	Өсөлтийн үнэлгээ	1.ЭХ- ийн эргэц  2.Авлагын эргэц  3.Өөрийн хөрөнгийн ашигт ажиллагаа	1.Даатгалын хураамжийн орлого /Оны эхний ба эцсийн эргэлтийн хөрөнгийн дундаж 2.Даатгалын хураамжийн орлого/Оны эхний ба эцсийн авлагын дундаж 3.Цэвэр ашиг/Өөрийн хөрөнгө <i>/Зөвхөн жилийн эцэст тооцно/</i>		
---	------------------	--	---	--	--

Боловсруулсан:

Хянан шалгагч: ..... /

/

Огноо: .....

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны ... дугаар сарын ...-ны өдрийн ... дүгээр тогтоолоор баталсан “Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ын арван есдүгээр хавсралт

## ЭРТ АНХААРУУЛАХ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ АРГАЧЛАЛ

### 1. Жилийн нийт ба цэвэр хураамжийн өөрчлөлт

Энэ нь даатгалын эрсдэлийн нэг томоохон үзүүлэлт юм. Хураамжийн огцом өсөлт, бууралт нь байгууллагын стратеги бусад хүчин зүйлүүдийг өөрчлөхөд хүргэж болно. Тухайлбал огцом өсөлт нь мэдээлэл, програм, нягтлан бодох бүртгэл, бусад дотоод хяналт, үйл ажиллагааны системд огцом нөлөө үзүүлэх эрсдэлийг авчирдаг. Өсөлт нь ихэвчлэн шинэ зах зээлд нэвтрэх, зах зээлд эзлэх хувийг нэмэгдүүлэх оролдлогыг харуулдаг. Давхар даатгалын нэмэлт хэлцлүүд мөн орлогын өсөлтийг авчрах бөгөөд ингэснээр эрсдэлийг нэмэгдүүлнэ. Зарим тохиолдолд үнээ өрсөлдөгчдөөсөө хэт буулгах тохиолдол байдаг. Ингэснээр даатгагчид доогуур үнэлгээний улмаас бага хэмжээний хураамжид их хэмжээний эрсдэл үүрэх, үүнээс үүдэн илүү их хөрвөх чадвартай хөрөнгө шаардах нөхцөлийг бүрдүүлдэг. Эсрэгээр хураамжийн бууралт нь зах зээлд эзлэх хувийг бууруулдаг. байгууллагын цалин, түрээс зэрэг тогтмол зардлын улмаас зардлын харьцаа нэмэгдэнэ. Өөрөөр хэлбэл тогтмол зардал нь компанийн бууралттай орлогын хувьд илүү өндөр хувийг эзлэн улмаар ашгийг бууруулахад нөлөөлнө.

Харьцаа:

/ Жилийн нийт ба цэвэр хураамжийн өөрчлөлт =(Тайлант үе-өмнөх үе) / Өмнөх үе

*Боломжит түвшин:*

33% >= Жилийн нийт ба цэвэр хураамжийн өөрчлөлт >=-33%

### 2. Даатгалын эрсдэлийн харьцаа:

Цаг агаар, газар хөдлөлт, гал түймэр болон бусад гамшгийн хохирол тодорхойгүй байдгийн нэгэн адил ердийн даатгал нь маш их хэлбэлзэлтэй байдаг. Хосолсон харьцаа 80-120% гэж үзье. Хэрэв цэвэр хураамж 100 бол ашиг эсхүл алдагдлын дээд хэмжээ 20 байна. Хувьцаа 50 гэвэл харьцаа 100-г 50-д хуваагаад 2 гарна. Хосолсон харьцаа 80 гэвэл даатгалын ашиг 20, харин 120 гэвэл даатгалын алдагдал -20 байна. 80 үед хувьцааны өгөөж 40% бол 120 үед хувьцааны өгөөж -40% болно. Энд цэвэр эрсдэлийн харьцаа 2 үед хувьцааны өгөөж -40-өөс 40 хүртэл хэлбэлзэж байна. Цэвэр эрсдэлийн харьцааг одоо 5 гэе. Хувьцаа адил 50 гэвэл хураамжийн хэмжээ 250 болно /хувьцаа\*эрсдэлийн харьцаа=50\*5/. Одоо хосолсон харьцаа 80 бол даатгалын ашиг 50, хувьцааны өгөөж 100 буюу 50-ийн ашиг дээр 50-ийн хувьцааг нэмсэнтэй тэнцүү болно. Харин 120 үед 50-ийн алдагдалтай, хувьцааны өгөөж -100 буюу 50-ийн алдагдлыг хувьцаанд хуваасантай тэнцэнэ. Үүнээс үзэхэд эрсдэлийн харьцаа өсөхөд даатгалын алдагдлын магадлалт хэмжээ мөн адил хувиар өсөж, харин хувьцаа хэвээр үлдэх ба үүнд үзүүлэх боломжит нөлөөлөл мөн дээрх хувиар өсөхөөр байна. Даатгагчийн хувьд эрсдэлийн харьцааг хувьцааны өгөөжийг өндөр байлгах зорилгоор аль болох өндөр байлгахыг хүсдэг. Харин зохицуулагч нь эрсдэлийн харьцаа өндөр, даатгалын үр дүн хасах байвал тухайн байгууллагын хувьцаанд сөргөөр нөлөөлнө

хэмээн болгоомжтой ханддаг. Өмнөх практикаас энэ харьцаа 3-аас дээшгүй байх боломжтойг харуулдаг. Нийт харьцааны хувьд давхар даатгал нэмэгдэн орж ирэх бөгөөд давхар даатгалын эрсдэлийг багтаасан байна. Иймээс мөн хязгаарлалт байх шаардлагатай.

1/ Цэвэр эрсдэлийн харьцаа=Цэвэр хураамж / Эздийн өмч

*Боломжит түвшин:*

Цэвэр эрсдэлийн харьцаа  $\leq 3$

2/ Нийт эрсдэлийн харьцаа= Нийт хураамж / Эздийн өмч

*Боломжит түвшин:*

Нийт эрсдэлийн харьцаа  $\leq 7$

3. Нэхэмжлэлийн харьцаа:

Дэлхийн банк хөгжингүй орны хувьд 50%-80% гэж зөвлөдөг.

Харьцаа:

Төлсөн нэхэмжлэл / Орлогод тооцсон цэвэр хураамж (Урт хугацааны даатгалын компани байвал даатгалын цэвэр орлогоор хуваана)

*Боломжит түвшин:*

75%  $\geq$  Нэхэмжлэлийн харьцаа  $\geq 30\%$

4. Зардлын харьцаа:

Дэлхийн банк хөгжингүй орны хувьд 25%-50% гэж зөвлөдөг.

Харьцаа:

Зардал / Орлогод тооцсон цэвэр хураамж (Урт хугацааны даатгалын компани байвал даатгалын цэвэр орлогоор хуваана)

*Боломжит түвшин:*

60%  $\geq$  Зардлын харьцаа  $\geq 25\%$

5. Хосолсон харьцаа:

Хосолсон харьцаа 100%-иас их нөхцөлд компани хөрөнгө оруулалтын ашигтай ажиллах шаардлагатай. Хөрөнгө оруулалтын өндөр орлоготой үед компани зах зээлд эзлэх хувиа нэмэгдүүлэх зорилгоор хураамжаа бууруулан алдагдал хүлээж тэр алдагдлаа хөрөнгө оруулалтаар нөхөхийг эрмэлздэг. Энэ тохиолдолд хөрөнгө оруулалтын орлого буурвал компани санхүүгийн эрсдэлд орох магадлалтай.

Харьцаа:

Төлсөн цэвэр нэхэмжлэл ба зардал / Орлогод тооцсон цэвэр хураамж (Урт хугацааны даатгалын компани байвал даатгалын цэвэр орлогоор хуваана)

*Боломжит түвшин:*

105%  $\geq$  Хосолсон харьцаа  $\geq$ 85%

6. Өөрт үлдээх эрсдэлийн харьцаа:

Энэ нь компани хэдий хэмжээний бизнес өөртөө үлдээх, хэдийг давхар даатгавал зохихыг тодорхойлно.

Харьцаа:

Цэвэр хураамж / Нийт хураамж

*Боломжит түвшин:*

80%  $\geq$  Өөрт үлдээх эрсдэлийн харьцаа  $\geq$ 40%

7. Эздийн өмчийн өөрчлөлтийн харьцаа:

Энэ харьцаа нь компанийн хувьцааны жил жилийн өөрчлөлт үйл ажиллагаанд нь хэрхэн нөлөөлж байгааг харуулна. Компани төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангахгүй болоход хувьцаа хамгийн сүүлийн хамгаалалт нь болдог ба үүнд орох өөрчлөлт нь компанийн санхүүгийн эрсдэлийн чухал үзүүлэлт болдог.

Харьцаа:

(тайлант үеийн Эзэмдийн өмч ба нэмж оруулсан хөрөнгийн ялгавар-өмнөх үеийн Эздийн өмч ба нэмж оруулсан хөрөнгийн ялгавар) / Өмнөх үеийн Эздийн өмч ба нэмж оруулсан хөрөнгийн ялгавар

*Боломжит түвшин:*

-10%  $\geq$  Эздийн өмчийн өөрчлөлтийн харьцаа  $\geq$ 25%

8. Авлагын сорил:

Их хэмжээний өр төлбөртэй даатгалын мэргэжлийн оролцогч дампуурвал компанид томоохон эрсдэл үүсгэнэ. Авлага төлөгдөхгүй бол компанийн хувьцаанд нөлөөлнө.

Харьцаа:

Хураамжийн авлага / Эздийн өмч

*Боломжит түвшин:*

20%  $\geq$  Авлагын сорил

9. Хувьцаанд эзлэх холбогдох этгээдийн өр:

Тухайн группэд санхүүгийн хүндрэл учирвал мөнгө төлөгдөхгүй байх эрсдэлтэй.

Харьцаа:

Холбогдох этгээдээс төлөх өр / Эздийн өмч

*Боломжит түвшин:*

10%  $\geq$  Хувьцаанд эзлэх холбогдох этгээдийн өр

10. Өр төлбөрт эзлэх Эздийн өмчийн эзлэх хувь хэмжээ:

Энэ нь чухал харьцаа бөгөөд даатгагч даатгуулагчийн өмнө хүлээх үүргийн биелэлтийг харуулах үзүүлэлт юм. Энэ харьцаа бага бол даатгагчид учирч болох гэнэтийн урьдчилж хараагүй эрсдэл /даатгалын алдагдал, хөрөнгө оруулалтын алдагдлыг тооцохгүйгээр гамшгийн эрсдэл, давхар даатгагчийн дампуурал зэрэг/-д санхүүгийн чадавх хүрэлцэхгүй болно. Компанийн өр төлбөрийн тооцоололд тодорхой тохируулга хийх шаардлагатай ба жишээ нь хөрөнгийн илүү үнэлгээ, өр төлбөр нөөцийн доогуур үнэлгээ зэргийг дурдаж болно.

Харьцаа:

Эздийн өмч / (өр төлбөр ба зохицуулагчаас шаардсан нөөц)

*Боломжит түвшин:*

Өр төлбөрт эзлэх Эздийн өмчийн хэмжээ  $\geq 25\%$

11. Хөрөнгө оруулалтын өгөөж:

6 сарын хугацаатай ЗГ өрийн бичгийн дундаж хувьтай тэнцүү байна. Өндөр өгөөж өндөр эрсдэлийг дагуулдаг.

Харьцаа:

Хөрөнгө оруулалтын цэвэр орлого / оны эхэн ба эцсийн дундаж хөрөнгө оруулалт

*Боломжит түвшин:*

Хөрөнгө оруулалтын өгөөж  $>$  ЗГ өрийн бичгийн 6 сарын дундаж хүү

12. Хөрвөх харьцаа:

Даатгалын компанийн тогтвортой үйл ажиллагаа нь компанийн хөрвөх эрсдэлийн удирдлага сайн байгааг харуулна. Олон даатгагч энэ харьцаа алдагдсаны улмаас дампууралд хүрч байсан.

Харьцаа:

(Бэлэн мөнгө+ЗГ бонд+Хадгаламж) / Нийт өр

*Боломжит түвшин:*

95%  $\geq$  Хөрвөх харьцаа

13. Аюулгүй байдлын харьцаа:

Нөөцөд нөхөн төлбөрийн, хохирлын үнэлгээний зардлын, хуулийн зардлын болон УБНХН орно. Хэрэв төлөөгүй нэхэмжлэлийн дүн эздийн өмчөөс 1.5 дахин өндөр бол нэхэмжлэлийн хариуцлагын 10 хувийн дутуу тооцоо нь эздийн өмчийн 15%-тай тэнцүү байна. Харьцаа 5:1 бол нэхэмжлэлийн хариуцлагын 10% дутуу тооцоо нь хувьцааны 50% болно гэсэн үг.

Харьцаа:

Нэхэмжлэлийн цэвэр нөөц (төлбөрийн, хохирлын үнэлгээний зардлын, хуулийн зардлын болон УБНХН) / Эздийн өмч

*Боломжит түвшин:*

2.5 >= Аюулгүй байдлын харьцаа

14. Эздийн өмчийн өгөөж:

Эздийн өмчийн өгөөж нь аливаа компанийн санхүүгийн гүйцэтгэлийг хэмжих нэг чухал хэмжүүр юм. Хасах эсхүл бага үзүүлэлт нь компанийн санхүүд асуудал үүссэнийг харуулна. Энэ үзүүлэлт нь хөрөнгө оруулагчийн шийдвэрт нөлөөлнө.

Харьцаа:

Цэвэр орлого / ( Эздийн өмчийн оны эхэн ба эцсийн дүнгийн дундаж хувь)

*Боломжит түвшин:*

Өмнөх тайлант үеийн бүх компанийн дундаж > Эздийн өмчийн өгөөж

15. Нэхэмжлэлийн нөөцийн хүрэлцээт байдлын харьцаа:

Тухайн жилд байгуулсан нөөц тухайн жилийн нэхэмжлэлд хангалттай эсэхийг харуулдаг хэмжүүр юм. Нэхэмжлэлийг хэт багаар тооцсон бол ашиг нь өндөр гарна. Энэ тохиолдолд тайланд залруулга хийгдэнэ.

Харьцаа:

Өмнөх оны шийдвэрлээгүй хохирлын илүүдэл, дутагдал / Эздийн өмч

*Боломжит түвшин:*

-10% >= Нэхэмжлэлийн нөөцийн хүрэлцээт байдлын харьцаа